



ҮЛС ТӨР

БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ТУШАА БОЛСОН ШИЙДВЭРҮҮДИЙГ ЦЭГЦЭЛЛЭЭ

II нүүрт

ДЭЛХИЙ

БАРУУНЫХАН ОХУ-ЫГ ШҮҮМЖЛЭВ

VI нүүрт

Дугаарын **60** мөр

Хэний мөнгөөр зугаалж явааг нь шалгах хэрэгтэй

Ж.ОТГОНМЯГМАР

Манай төрийн өндөрлөгүүд сүүлийн үед айлчлал хэмээх гоё нэртэй зугаалгыг их хийдэг болжээ. Тэгээд ганц нэгээрээ ч биш бөөн бөөнөөрөө айлчилж, туршлага судлах болжээ. Уг нь МАН гарсан цагаасаа л улсын авдар мөнгөтэй гэж бодож байсан юм. Гэтэл аваад нээсэн чинь юу ч алга. Монгол Улсын эдийн засаг хүнд байна гээд л албан хаагчдынхаа цалинг хасч, оюутны тэтгэлэг, бүтээн байгуулалтуудыг зогсоосон гээд бүгдийг хасч, танаад байгаа. Бүр улс орон дампуурлын ирмэгт ирчихлээ гэж сүржин мэдэгдэл хийгээд л хүүхдийн 20 мянгаа ч өгч чадаагүй хэмээн олон хүүхдийн хоолыг хасч байгаа билээ.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

## БААР, НОХОЙ...

### ТАНДААД Л БАЙХ ЮМ, ЗОРИГГҮЙ ХОТЫН ДАРГАТАЙ БОЛЖЭЭ



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Н.ПУНЦАГБОЛД

УИХ болоод нийслэлд үнэмлэхүй ялалт байгуулсан МАН ажлаа эхэлснээс хойш бүтэн хоёр сар өнгөрч байхад

дорвитой ажил юу ч хийсэнгүй. Өнгөрсөн дөрвөн жилд АН-ын хийсэн бүхнийг зогсоож, болиулж, өөрчилж байгааг эс тооцвол шүү дээ. Яах вэ, хурал хуйгаа сурсан юм боло-

хоороо нэг юм хийгээд байгаа. Тухайлбал, хотын удирдлага өнгөрсөн хугацаанд тандаад л байх юм. Хотын мээр Су.Батболд баарыг 12:00 цагт хаана гэж тандав. Үнсгэлжин, бэлгийн

сулралтайгаараа дуудуулан барин хүмүүс эсэргүүцэхээр тийм шийдвэр гаргаагүй гэж айлаа. Хот бол сум биш. Хотын иргэд архичид биш.

Үргэлжлэл нь III нүүрт

ШҮҮХИЙН ТАНХИМААС

Шүүхийн шийдвэр "Сентерра Гоулд Монголия" ХХК-ийн талд гарчээ

Х.НОРЖИН

Н.Алтанхуяг, Ч. Сайханбилэг нарын толгойлсон Засгийн газрууд Монгол Улс эдийн засгийн хямралыг хохирол багатай давж гарахад алт хэмээх өнгөт металлыг эдийн засгийн эргэлтэд оруулах явдал гэж тодорхойлж, өнгөрсөн хавар буюу 2016 оны хоёрдугаар сарын 4-ний өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар "Ноён уул"-ыг тусгай хамгаалалтад авах, тус ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг тогтоох тухай төслийг хэлэлцээд гишүүдийн 71 хувийн саналаар дэмжигдсэнээр Гацууртын орд эдийн засгийн эргэлтэд орохоор болсон юм. Тухайн үед Уул уурхайн сайд асан Р.Жигжид "УИХ чухал шийдвэр гаргалаа. Энэ нь стратегийн ач холбогдол бүхий Гацууртын ордыг эзэмших тухай шийдвэр юм. УИХ-ын тогтоол хоёр заалттай.

Үргэлжлэл нь II нүүрт

ОНЦЛОХ МЭДЭЭ

### Азийн олимпын зөвлөлийн хуралд итгэл тавилаа

Азийн олимпын зөвлөл (АОЗ)-ийн 35 дахь удаагийн Ерөнхий ассамблей Вьетнам улсын Данан хотноо болж өндөрлөлөө.

Хуралд ОУОХ-ны Ерөнхийлөгч Томас Бах, АОЗ-ийн Ерөнхийлөгч Шейх Ахмад Аль Фахад Аль Сабах болон ОУОХ-ны гишүүд, АОЗ-ийн Гүйцэтгэх зөвлөлийн гишүүд, ОУОХ-ны эв санааны нэгдлийн мэргэжилтнүүд оролцож, тайлан мэдээг хэлэлцэв. АОЗ-ийн Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн, Мэдээлэл ба статистикийн хорооны дарга, МҮОХ-ны Ерөнхийлөгч Д.Загдсүрэн энэхүү хуралд "Рио 2016" олимпын наадамд Азийн тамирчид оролцсон судалгаа" сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлээ. Тэрбээр Азийн олимпын зөвлөлийн Ерөнхий



ассамблейд оролцсон ОУОХ-ны Ерөнхийлөгч Томас Бахтай уулзав.

Түүнчлэн, Ерөнхий ассамблейн үеэр "Сапоро-2017" Азийн өвлийн наадам, "Жакарта-2018" Азийн наадам, "Ашхабад-2017" Азийн танхимын болон тулааны спортын наадмыг Зохион байгуулах хороодын илтгэлийг сонсчээ. Мөн АОЗ-

ийн хүндэт одонгоор БНСУ, Афганистан, Энэтхэг улсын төлөөлөл гурван хүнийг шагнаж урамшуулахын зэрэгцээ 2026 онд 20 дахь удаагийн Азийн наадмыг зохион байгуулах хотоор нэр дэвшигч Япон улсын Нагояа хотыг батламжилж, зохион байгуулах хотын гэрээнд гарын үсэг зурах ёслолд оролцсон байна.

## "ШИНЭ ТӨГӨЛ" ЦЭЦЭРЛЭГТ ТАВТАЙ МОРИЛ

Олон Улсын стандартад нийцсэн "Шинэ төгөл" цэцэрлэг "Маршал таун" хотонд нээгдэж, 2016-2017 оны хичээлийн шинэ жилийн элсэлтээ авч эхэллээ. "Шинэ төгөл" цэцэрлэг нь нийслэлийн хамгийн цэвэр агаартай бүсэд өөрийн зориулалтын, бие даасан байрандаа танай хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд сургахын зэрэгцээ зөв монгол иргэн болж төлөвшихөд бэлтгэнэ.

**АНГИ БҮРИЙГ КАМЕРЖУУЛСАН ТУЛ ТА ХҮҮХДЭЭ АЖИЛ БОЛОН ГЭРЭЭСЭЭ ХЯНАХ БОЛОМЖТОЙ.**

Нэг ангид хоёр багштай ба анги дүүргэлт 15-20 хүүхэдтэй. Манай цэцэрлэг нь пластик ширээ, сандал, тавилга, тоглоомоос татгалзаж хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, байгалийн гаралтай цэцэрлэгийн стандартыг бүрэн хангасан модон ширээ, сандал, тавилгатайгаас гадна АНУ болон Европын сэтгэхүй хөгжүүлэх, сэдэвт, тоо тооллын, бие бялдар хөгжүүлэх тоглоом мөн Японы сургалтын хэрэглэгдэхүүнтэй. Сургалтын хөтөлбөрийн хувьд сургуулийн өмнөх боловсролын ЦӨМ хөтөлбөрийг The Academy of English - ийн JOLLY KIDS 4-5 настай хүүхэд зориулсан Англи хэлний сургалттай хослуулан хэрэгжүүлж байгаагаараа онцлог юм.

Сургалтаараа хүүхдийг амьдрах ухаан, хэл яриа, тоо тоолол, ёс заншил, урлаг соёл, байгаль болон хүрээлэн буй орчныг танин мэдэхэд сургахаас гадна хүүхдийн биеэ даах, аливаа асуудлыг өөрөө шийдэх, нийгэмших, баг хамт олноор ажиллах, бүтээлч чадварыг хөгжүүлэнэ.

Түүнчлэн манай чадварлаг тогооч нарын бэлтгэсэн хоол нь зөвхөн хүүхэд зориулсан байдаг төдийгүй байгалийн органик гаралтай, амин дэм, витаминаар баялаг, өөх тос багатай, шарж хуураагүй байгаагаараа давуу талтай юм. Үүнээс гадна манай гал тогоо нь өндөр зэрэглэлийн Европын техник төхөөрөмжтэй тул хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй юм.

**ТАНЫ БЯЦХАН ҮРС ЗӨВ МОНГОЛ ХҮН БОЛНО**  
Холбоо барих утас: 99094864

## МОНГОЛЫН МЭДЭЭ

Манай сонины IV улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд **64** дугаар

**Захиалгын үнэ 18000**

Монгол шуудан: 70078977  
УБ шуудан: 70127027  
Скай пост: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025

ХААН банк				Хугалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2257.00	2273.00	ФУНТ	2878.00	2979.00	АМ.ДОЛЛАР	2260.00	2273.00
ЕВРО	2508.00	2576.00	РУБЛЬ	33.90	36.80	ЕВРО	2511.00	2588.00
ИЕН	22.17	22.79	ЮАНЬ	337.50	341.30	ИЕН	22.13	22.89
						ФУНТ	2895.00	2982.00
						РУБЛЬ	34.13	37.24
						ЮАНЬ	337.50	341.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар



# УЛС ТӨР

### МЭДЭЭЛЭЛ

### АСУУДЛЫН МӨРӨӨР

## Гурван аймагт дахин сонгууль явуулна

Өнгөрсөн зургаадугаар сарын 29-нд УИХ-ын болон аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгууль болсон. Гэтэл Дархан-Уул, Сүхбаатар, Өмнөговь аймгийн хэд хэдэн тойрогт ИТХ-ын сонгууль маргаантай явагдсан гэдэг нь шүүхээр тогтоогдож, дахин сонгууль явуулахаар болжээ. УИХ-ын сонгуультай холбоотой гомдол маргаан харьцангуй бага гарсан гэж цагдаа болоод бусад байгууллагаас мэдээлж буй. Харин аймаг, нийслэлийн ИТХ-ын сонгуультай холбогдуулж Дархан-Уул, Өмнөговь, Сүхбаатар аймагт маргаан гарсан байна. Тодруулбал, Дархан-Уул аймагт 15 бие даагчийг аймгийн сонгуулийн хороо нь бүртгээгүй гэсэн шалтгаанаар маргаан үүсчээ. Маргааныг аймгийн шүүхээр авч хэлэлцээд аймгийн сонгуулийн хороог буруутай гэж үзсэн тул дахин сонгууль явуулахаар болсон байна. Мөн Өмнөговь аймагт ИТХ-ын сонгуулийн хоёр тойрог, Сүхбаатар аймагт ИТХ-ын сонгуулийн нэг тойрогт маргаан гарч, шүүхээр буруутай нь тогтоогдсон тул дээрх гурван тойрогт дахин сонгууль явуулахаар болжээ. Дашрамд дуулгахад, Орхон аймгийн ИТХ-ын сонгуулийн үеэр маргаан гарсан. Одоогоор шүүх буруутай эсэхийг тогтоогоогүй байгаа тул дахин сонгууль болох эсэх нь тодорхойгүй байна. Маргаан гарсан тойрогт явуулах дахин сонгуулийг авардугаар сарын 19 буюу сум, дүүргийн ИТХ-ын өдөр хамт зохион байгуулах юм.

Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалт 2011 онд 4.6 тэрбум ам.долларт хүрч байсан бол 2016 оны эхний хагас жилийн байдлаар ердөө 35 сая ам.доллар болж буураад байгаа. Тэгвэл хөрөнгө оруулалт ингэж буурахад бодит хүчин зүйлсийн зэрэгцээ, төрийн захиргааны болон хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой субъектив нөлөө байгаа эсэхийг тогтоох шаардлага гараад байгаа. Тиймээс Монгол Улсын Ерөнхий Сайдын захирал Жаргалтзориг Хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдэд төрийн захиргааны болон хуулийн байгууллагаас хууль бусаар дарамт учруулсан, хүнд суртал гаргасан, үндэслэлгүйгээр мөрдөн



# БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ТУШАА БОЛСОН ШИЙДВЭРҮҮДИЙГ ЦЭГЦЭЛЛЭЭ

шалгах зэргээр эрх ашгийг нь хохироосон асуудлыг судалж, дүгнэлт гаргах үүрэг болгосон. Улмаар ажлын хэсгийг Хууль зүй, Дотоод хэргийн сайдаар ахлуулан ажиллуулж эхэлсэн байна. Энэ хүрээнд хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн холбоотой хууль тогтоомж, дүрэм журмын жагсаалтыг гаргаж, захиргааны хэм хэмжээний актуудыг хянаж үзсэн аж.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад 598 хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаагаас 87 хууль нь аж ахуйн нэгжийн, 24 хууль нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулж байна. Түүнчлэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар 110 тусгай зөвшөөрлийг төрөлжүүлэн нэгтгэж олгохоор зохицуулжээ. Харин захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа

...Энэхүү ажлын хүрээнд холбогдох байгууллагуудаас гаргасан нийтээр дагаж мөрдүүлж байгаа шийдвэрүүдийг хянаж үзэхэд МХЕГ нийт 22 тушаалыг хууль тогтоомжид заасны дагуу хянуулж бүртгүүлэхгүйгээр дагаж мөрдүүлж байсан зөрчил илэрчээ...

971 захиргааны хэм хэмжээний актаас хөрөнгө оруулалт, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчтэй холбоотой сайдын тушаал 168, агентлагийн даргын тушаал 25, нийслэлийн Засаг даргын захирамж 44, нийт 237 шийдвэр байгаа аж. Тэдгээрийг хянаж үзэхэд, холбогдох хуулиудад нийцэхгүй, Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагыг хангахгүй сайдын тушаал 78, агентлагийн даргын тушаал 12, аймаг нийслэлийн Засаг даргын захирамж 10 нийт 100 шийдвэр байгаа нь тогтоогджээ.

Тиймээс ХЗДХА хөрөнгө оруулагчдад тээг болж хүндрэл чирэгдэл учруулж буй 86 шийдвэрийг хүчингүй болгох, 14 шийдвэрийг шинэчлэн баталж бүртгүүлэх тухай саналаа холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлээд байгаа юм байна. Харин Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд

заасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зургаан журам бүртгэлтэй байгаа. Эдгээрээс Уул уурхайн сайдын 2015 оны “Үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай” 15 дугаар тушаалаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дугаарыг цахим хэлбэрээр олгох, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл, түүний эрх олгох үйлчилгээний хөлсний хэмжээг баталсан. Энэ нь Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжид нийцээгүй тул хүчингүй болгох бүртгэлээс хасах саналыг ХЗДХА-ийн сайдын албан бичгээр Уул уурхай хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлээд байгаа аж. Түүнчлэн Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн үйлдвэрлэх, угсрах, засварлах тусгай зөвшөөрөл олгох журам батлах тухай” 155 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын

2011 оны “Импорт, экспортын лиценз олгох журам батлах тухай” 343 дугаар тушаалууд нь Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжид нийцээгүй тул хүчингүй болгож, бүртгэлээс хасах саналыг холбогдох сайд нарт уламжилжээ.

Энэхүү ажлын хүрээнд холбогдох байгууллагуудаас гаргасан нийтээр дагаж мөрдүүлж байгаа шийдвэрүүдийг хянаж үзэхэд МХЕГ нийт 22 тушаалыг хууль тогтоомжид заасны дагуу хянуулж бүртгүүлэхгүйгээр дагаж мөрдүүлж байсан зөрчил илэрчээ. Тиймээс дээрх тушаалуудыг хуульд нийцүүлэх, хүчингүй болгох арга хэмжээ авах санал хүргүүлсэн байна. Тиймээс хөрөнгө оруулалтад хөндөлсөж, бизнес эрхлэгчдэд тушаа болсон тушаал шийдвэрүүдийг цэгцэлж, хуулиас давсан зарим журмуудыг журамлаж эхэллээ гэж олгойж болох нь ээ.

## МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

---

Ерөнхий эрхлэгч:	С.ГАНТОГОО
Орлогч эрхлэгч:	Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158
Хариуцлагатай нарийн бичгийн дарга:	Э.ЭНХЦЭЦЭГ 88873012
Ахлах редактор:	Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба:	Н.ПУНЦАГБОЛД 88096454
Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:	Б.ӨНӨРТОГТОХ 88006842
Гэрэл зургийн алба:	Г.АРГУУЖИН 96017873
Компьютерийн алба:	Б.ГАНЗОРИГ 99998796
Маркетинг, зар сурталчилгааны алба:	Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710
Захиалга, борлуулалтын алба:	М.ДАВААДУЛАМ 99042510
	Э.САЙНЗАЯА 99197866
Дугаарыг эрхлэсэн:	Э.ЭНХЦЭЦЭГ

---

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

**Редакцийн хаяг:**  
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/.  
2 давхар. 209, 211 тоот

**Харилцах утас, факс:**  
976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.



## Нийслэл нэг намын атганд бүрэн орсон гэв

НИТХ дахь АН-ын бүлгээс НИТХ-ын Тэргүүлэгчдийн 11 суудлын талаар мэдэгдэл гаргажээ. Мэдэгдэлд “НИТХ дахь АН-ын бүлгээс 2016 оны едүгээр сарын 14-ний өдөр НИТХ-ын дарга Ц.Сандуйд “Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байнгын ажиллагаатай, нээлттэй, шуурхай ажилладаг зарчмаасаа ухарч, хуралдааны дэгээ зөрчин 2016 оны долдугаар сарын 28, наймдугаар сарын 25-нд ээлжит хуралдааныг хуралдуулаагүй хариуцаагүй үйлдээ залруулж, нэгдсэн хуралдааныг есдүгээр сард багтаан хуралдуулахыг шаардаж байна” гэсэн шаардлага хүргүүлсэн. Бүлгийн энэхүү хууль ёсны шаардлагын дагуу 2016 оны есдүгээр сарын 22-ны өдөр НИТХ-ын хоёрдугаар хуралдааныг хуралдуулж Ажлын хороо, Дэд хороодын бүрэлдэхүүнийг баталжээ. Нэгдсэн хуралдаанд МАН-ын бүлгээс нэмэлтээр хэлэлцүүлсэн НИТХ-ын Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнд хоёр төлөөлөгчийг нөхөн томилох асуудлаар АН-ын бүлэг зарчмын зөрүүтэй саналаар завсарлага авах хүсэлт тавьсан боловч Ц.Сандуй хэт нэг талыг барин хуралдааны дэгийн

4.6 дахь заалт /нэгдсэн хуралдаан дээр хэлэлцэж буй тухайн асуудлаар нам, эвслийн бүлэг санал гаргасан тохиолдолд Хурлын дарга завсарлага өгнө/-ыг зөрчиж, АН-ын бүлэгт Тэргүүлэгчдийн бүрэлдэхүүний асуудлаар зөвшилцөх завсарлага өгсөнгүй. Шийдвэр гаргах төвшинд олон түмний сонголтын харьцаагаар хуваарилалт оногдох нь ардчиллын шударга зарчим юм. НИТХ-ын Тэргүүлэгчдийн 11 суудлыг дээрх хоёр намын авсан суудлын хувьтай харьцуулж үзвэл МАН-д найм, АН-д гурван суудал ногдохоор байна. Гэтэл НИТХ дахь МАН-ын бүлэг хэт олонхоороо хүч түрж, дэгээ зөрчин хүчээр санал хураалт явуулж, нийслэлчүүдийн сонголтыг үл хүндэтгэсэн шийдвэр гаргалаа. НИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал нь сөрөг хүчний хяналтгүй, нэг намын байгууллага мэт хаалттай ажиллах нь тодорхой боллоо. Иймд Тэргүүлэгчдийн хурал хуралдах бүрт АН-ын бүлэг хэвлэл мэдээллийн байгууллагуудад нээлттэй хуралдаж, хурлаас гарсан тогтоол шийдвэрийг нийслэлчүүддээ хүргэж, эрх баригчдад тогтмол хяналт тавьж ажиллах болсноо мэдэгдье” гэжээ.

### ШҮҮХИЙН ТАНХИМААС

## Шүүхийн шийдвэр “Сентерра Гоулд Монголиа” ХХК-ийн талд гарчээ

Үргэлжлэл. Түүрч нь I нүүрт

Нэгдүгээрт, Монгол Улсын төр тус ордын 34 хувийг эзэмших, хоёрдугаарт төслийг хэрэгжүүлэхдээ Ашигт малтмалын тухай хуулийн дагуу асуудлыг шийдвэрлэхийг Засгийн газарт даалгасан. Бидний зорилго бол Оюутолгой, Гацуурт, Цагаан сувгарга зэрэг том ордыг стратегийн эргэлтэд оруулах. Энэ зорилт шат дараатай урагшилж байна. Гацууртын ордын хувьд нийт хөрөнгө оруулалтын

хэмжээ 215.9 сая ам.доллар бол борлуулалтын орлого нь 1.8 тэрбум ам.доллар, татвар хураамж төлбөр хэлбэрээр Засгийн газарт 438.8, сая ам.доллар төлөгдөнө. Цэвэр ашиг нь 90.6 сая ам.доллар гэсэн тооцоо бий. Засгийн газарт ногдох мөнгөн урсгалын нийт хэмжээ 432.3 сая эм.доллар буюу нийт мөнгөн урсгалын 68.2 хувь нь манайд ногдоно гэсэн эдийн засгийн үндэслэлтэй тооцоо гарсан” хэмээн сэтгүүлчдэд мэдээлж байлаа. Харамсалтай нь “Ноён уулаа аврах хөдөлгөөн”-ийхөн

Ашигт малтмалын газрын шийдвэрээр “Сентерра Гоулд Монголиа” ХХК-д Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг Гацууртад олгосон 431 А, 372А дугаар ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг хүчингүй болгуулахаар Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргаснаар “Сентерра гоулд Монголиа” ХХК тус ордыг ашиглах боломжгүй өнөөдрийг хүрээд байгаа билээ. нэхэмжлэгч тал ч шат шатны шүүхэд хандсаар өнөөдөр дээд шатны шүүхийн шийдвэр “Сентерра Гоулд” ХХК-ийн талд гарсан байна.

## Хоёр яамны ТНБД-ын сонгон шалгаруулалтыг хийнэ

Төрийн албаны зөвлөлөөс өнгөрсөн баасан гарагт Дорноговь, Төв, Хэнтий, Говьсүмбэр, Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, мөн Увс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалтад орох хүмүүсийг бүртгэсэн байна. Өчигдөр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын

яам, Эрчим хүчний яамны төрийн нарийн бичгийн дарга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Хүний Засаг даргын Тамгын газрын Ажлын албаны захиргаа хамтын ажиллагааны хэлтсийн дарга зэрэг албан тушаалын сонгон шалгаруулалтад орох хүмүүсийг бүртгэсэн. Тиймээс эдгээр албан тушаалын сонгон шалгаруулалт өнөөдөр болно.

## Намрын чуулганыг ирэх даваа гарагт нээнэ



УИХ-ын 2016 оны Намрын ээлжит чуулганыг аравдугаар сарын 03 буюу ирэх долоо хоногийн даваа гарагт нэхэхээр төлөвлөжээ. УИХ-ын чуулганы дэгийн тухай хуульд зааснаар Намрын чуулган жил бүрийн аравдугаар сарын 01-нд нээлтээ хийдэг.

Энэ удаад бямба гарагт таарч байгаа тул ирэх даваа гараг хүртэл хойшуулахаар болжээ. Намрын ээлжит чуулганаар Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуулийн төсөл, Хүний хөгжил сангийн 2017 оны төсвийн тухай хуулийн төсөл, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуулийн төсөл, “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд



# ҮЗЭЛ БОДОЛ

ҮЗЭЛ БОДОЛ

## БААР, НОХОЙ...

### ТАНДААД Л БАЙХ ЮМ, ЗОРИГГҮЙ ХОТЫН ДАРГАТАЙ БОЛЖЭЭ

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Шөнийн цэнгээний газар согтуучуудын үйлчлүүлдэг газар биш. Та эхлээд хотын хүн бол, хотын соёлд суралц гэж хүртэл хэлүүлж байж мэдрэв үү яав. Өчигдөр тэгж шийдээгүй шүү гэж хэлтсийн дарга нараараа албан ёсоор үг дайв. Эхний тандалт ингээд бут цохиулав. Хөдөөгийн биш хотын иргэд арай өөр юм хүсдэг гэдгийг тэр мэдэж авах шиг боллоо. Дараагийн тандалт судалгааг нохой дээр хийж үзэв. Золбин нохойд спираль тавихад зориулж нийслэлийн төсвөөс таван тэрбумыг гаргахаар болсон

утшилтай дарга нар учраа үнэхээр олохгүй байгаа бол АН-ын хийсэн ажлыг үргэлжлүүлчих л дээ. Тэгвэл ард түмэнд хэрэгтэй дээ.

#### Утааны улирал эхэллээ, тандах болов уу, бас яах бол

Гадаа цас орж, хүйтний ам наашилж байгааг санууллаа. Цаг агаар хүйтрэхтэй зэрэгцээд Улаанбаатар хот маань утаан “хөшиг”-өө татаж эхлэв. Өнгөрсөн хэдэн жилд Засгийн газар, нийслэлээс утаатай тэмцэх төсөл хөтөлбөр боловсруулж, бага ч болов утаа багассан, ядаж л хорт

хөтөлбөрийг элдэв шалтаг гаргаад зогсоочихоод, дараа нь 400 иргэн хохирлоо гээд л суржигнээд байна. Яг үнэндээ тэднийг хэн хохироов, одоогийн нийслэлийн удирдлагууд шүү дээ. Тэд юу ч гэж шалтаг хэлж болно. Угаасаа эвлүүлэхээс нураах нь амархан байдаг, бас шалтаг олддог. Гэтэл гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажил нийслэлээс нэг их хамаараад байхгүйгээр иргэд компанитайгаа тохироод л явчихна. Тэгээд ч тодорхой хэмжээнд ажил явж байсан юм билээ. Энэ бүхний дараа МАН дахин төлөвлөлтийн ажилд өөрсдийнхөө компанийг оруулах гэж л зогсоолоо гэж хардахаас өөр арга алга. За яах вэ, дахин төлөвлөлт хийхээр шалгарсан 10 гаруй компанийг нь сольж, МАН-ынхан өөрсдийнхөө компанийг оруулж болно оо, дүүрч. Гол нь иргэд хохирч болохгүй. Дээрээс нь утаатай тэмцэх хамгийн гол зүйл болох орон сууцжуулах ажил зогсч болохгүй юм. Үүнийг л сайн ойлгоосой. Ерөөсөө аливаа шинэ ажил, шийдвэр иргэдэд таалагдаггүй. Машиныг дугаараар нь хязгаарлаж хөдөлгөөнд оролцуулахаар болоход яаж шүүмжилж байлаа. Ардчилсан оронд ийм зүйл байж болохгүй гээд л дайрч байсан. Одоо яаж байна, дугаарын хязгаарлалтыг зогсоовол жагсахаар болсон байна. Нөхцөл байдал ингэж л бүрддэг. Гэтэл МАН-ынхан өнгөрсөн хугацаанд АН-ын эхлүүлсэн, хийсэн, тэдний тамгатай бүхнийг арчих зорилготой л ажиллах гэж оролдоод байна. Яг үнэндээ нийслэлд АН-ын тамгалсан бүхнийг арилгана гэвэл та нар юу ч хийж чадахгүй шүү дээ. Тэд зөв ажил, зөв жишиг тогтоогоод өгчихсөн. Одоо тэр жишгийг эвдээд, өөр шинэ юм хийнэ гэвэл та нарын толгой хүрэхгүй. Ингэж иргэд юу гэж хэлэхийг судалж тандаж байхын оронд өнгөрсөн дөрвөн жилд өрсөн суурин дээрээс “тоосго” нэмээд л яваач дээ. Тэгвэл харин та нар ард түмэнд таалагдана. Ерөөсөө та бүхний ганц зорилго чинь ард түмэнд таалагдах л биз дээ.

...Ардчилсан оронд ийм зүйл байж болохгүй гээд л дайрч байсан. Одоо яаж байна, дугаарын хязгаарлалтыг зогсоовол жагсахаар болсон байна. Нөхцөл байдал ингэж л бүрддэг. Гэтэл МАН-ынхан өнгөрсөн хугацаанд АН-ын эхлүүлсэн, хийсэн, тэдний тамгатай бүхнийг арчих зорилготой л ажиллах гэж оролдоод байна...

гэсэн мэдээлэл тарав. Сүүлдээ гичий нохойны савыг тайрч авах мэс ажилбар хийх гэж байгаа болохоос спираль биш гэж үзэв. Харин өчигдөр золбин нохойд биш эзэнтэйнохдынүржлийгзогсоохын тулд тодорхой ажлууд хийнэ. Гэхдээ яг спираль тавина, савыг нь авна, бооно гэсэн юм байхгүй. Бид судалж байна л болсон. Мөн өнөөх алдарт таван тэрбумыг огт худлаа яриа гэж үгүйсгэв. Нохой хэтэрхий олшироод байгаа болохоор түүнтэй тэмцэх цоо шинэ кампанит ажил эхлүүлж, багагүй мөнгө зарчих санаа олсон байх. Тэгээд тандалтын мэдээллээ цацтал хүчтэй эсэргүүцэлтэй тулж, ёстой ам руугаа алгадууллаа, хөөрхий. Хотын ажил нэг иймэрхүү л байна. Өнгөрсөн дөрвөн жилд АН-ынхан нийслэлийг удирдахдаа хийх шаардлагатай бүхий л ажлыг эхлүүлсэн, хийж байсан. МАН-ын

хий нь буурсан гэдэг. Хүмүүс ч ингэж ярьдаг. Олон ажил хийсэн дээ. Тэр дундаас хамгийн их ач холбогдолтой ажил нь гэр хорооллын дахин төлөвлөлт байлаа. Гэвч МАН нийслэлд ялсныхаа дараа л энэ ажлыг зогсоочихсон. Өнөөдөр өнөөх муу хэлүүлээд байсан бүрэн шаталтад зуухаа ч тараахаа больсон. Утаагүй түлшний асуудал ч “буддаа” боллоо. Хэдэн жилийн өмнө тараасан зуухнууд нь муудаад, бүрэн шаталтгүй болж эхэлж байгаа гэсэн. Тандаг айлынх нь маань эвдрээд дууссан гэнэ лээ. “Цэвэр агаар” сан гэж байсан алга болсон. Агаарын бохирдолттой тэмцэх үндэсний ам руугаа алгадууллаа, бас л одоо алга. МАН агаарын бохирдлын талаар А ч дуугарахгүй байна. Тэгсэн мөртлөө хамгийн үр дүнтэй ганц арга байсан гэр хорооллыг орон сууцжуулах

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



“Агсаа эвлүүлэхээс нураах нь амархан байдаг, бас шалтаг олддог. Гэтэл гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажил нийслэлээс нэг их хамаараад байхгүйгээр иргэд компанитайгаа тохироод л явчихна. Тэгээд ч тодорхой хэмжээнд ажил явж байсан юм билээ. Энэ бүхний дараа МАН дахин төлөвлөлтийн ажилд өөрсдийнхөө компанийг оруулах гэж л зогсоолоо гэж хардахаас өөр арга алга. За яах вэ, дахин төлөвлөлт хийхээр шалгарсан 10 гаруй компанийг нь сольж, МАН-ынхан өөрсдийнхөө компанийг оруулж болно оо, дүүрч. Гол нь иргэд хохирч болохгүй. Дээрээс нь утаатай тэмцэх хамгийн гол зүйл болох орон сууцжуулах ажил зогсч болохгүй юм. Үүнийг л сайн ойлгоосой. Ерөөсөө аливаа шинэ ажил, шийдвэр иргэдэд таалагдаггүй. Машиныг дугаараар нь хязгаарлаж хөдөлгөөнд оролцуулахаар болоход яаж шүүмжилж байлаа. Ардчилсан оронд ийм зүйл байж болохгүй гээд л дайрч байсан. Одоо яаж байна, дугаарын хязгаарлалтыг зогсоовол жагсахаар болсон байна. Нөхцөл байдал ингэж л бүрддэг. Гэтэл МАН-ынхан өнгөрсөн хугацаанд АН-ын эхлүүлсэн, хийсэн, тэдний тамгатай бүхнийг арчих зорилготой л ажиллах гэж оролдоод байна. Яг үнэндээ нийслэлд АН-ын тамгалсан бүхнийг арилгана гэвэл та нар юу ч хийж чадахгүй шүү дээ. Тэд зөв ажил, зөв жишиг тогтоогоод өгчихсөн. Одоо тэр жишгийг эвдээд, өөр шинэ юм хийнэ гэвэл та нарын толгой хүрэхгүй. Ингэж иргэд юу гэж хэлэхийг судалж тандаж байхын оронд өнгөрсөн дөрвөн жилд өрсөн суурин дээрээс “тоосго” нэмээд л яваач дээ. Тэгвэл харин та нар ард түмэнд таалагдана. Ерөөсөө та бүхний ганц зорилго чинь ард түмэнд таалагдах л биз дээ.”

Хүний эрхийн хөдөлгөөн  
М.Ичинноров

### Дугаарын 60 мөр

#### Хэний мөнгөөр зугаалж явааг нь шалгах хэрэгтэй

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Гэхдээ жирийн ард иргэдийнхээ нүдийг булгийтгал бүсийг нь чангалж байгаа ч ачир дээрээ өөрсдийн тансаглалд огтоос хасалт хийхгүй байгаа нь эмгэнэлтэй. Саяхан даа хоёрхон жилийн өмнө НИТХ-ын гишүүд туршлага судлахаар яваад төлбөрт унаж байсныг иргэд санаж байгаа байх. НИТХ-ын 10 орчим төлөөлөгч Бразил, Куба улс руу туршлага судлахаар яваад ирсэн. Гэвч тэдгээр төлөөлөгчдийг “төсвийн хөрөнгөөр хөлбөмбөг үзэж зугаалж яваад ирлээ” хэмээн цахим ертөнцөөр шуугиж өгсөн. Тиймээс ч тухайн үед нь УИХ-ын дарга З.Энхболд “Бразил явсан төлөөлөгчид зардлаа хувиасаа төл” гэсэн мэдэгдлийг хотын удирдлагуудад хүргүүлсэн юм. Улмаар туршлага судлах нэрээр зугаалсан гэх нөхдүүд төлбөрөө төрд буцааж төлсөн сайн туршлага байдаг. Тухайн үед буюу 2014 оны зургадугаар сарын 19-нд буюу МАН цөөн байх үедээ Бразил явсан төлөөлөгчдийн асуудлаар НИТХ-ын МАН-ын бүлгийн гишүүд мэдээлэл хийж байсан. Тэдний хэлж буйгаар улсын эдийн засаг хүндэрч, урсгал зардлаа хэмнэх УИХ-ын тогтоол гарсан байхад Бразил руу хөлбөмбөг үзэхээр явах нь зохимжгүй аж. Тиймээс үргүй зардлаа хэмнэхийн тулд яваагүй гэсэн тайлбарыг хэлж байсан. Мөн нийслэлийн данхайсан бүтцийг багасгаж, урсгал зардлыг хэмнэхийг нийслэлийн Засаг

дарга Э.Бат-Үүлээс шаардаж, шаардлага хүргүүлж байсан удаатай. Тухайн үеийн ухамсар МАН-ынханд одоо л хэрэгтэй байх юм уг нь. Үнэхээр л улс орон чинь дампуурах гээд байгаа юм бол айлчлал нэртэй аялал, зугаалгуудыг цэнзуртай болгох хэрэгтэй байна. Тэгэхгүй бол төрийн өндөр албан тушаал бүхий эрхмүүд аялал зугаалга хийгээд түүнийгээ баталгаажуулан патнаараа татуулсан шигээ цахим ертөнцөөр “гангарч” байх юм. Хямрал дээд цэгтээ тулж байхад эд нар хэний мөнгөөр явж байгааг шалгах хэрэгтэй бус уу. Зөвхөн төрийн байгууллагын ажилтан, албан хаагч, төлөөлөгчид ч бус УИХ-ын гишүүн, яам тамгын газрын дарга, сайдууд ч гадаад дотоодын томилолт, айлчлалынхаа тайлан дүн мэдээг олон нийтийн телевиз, сонинноор ил тод мэдээлдэг болох нь зөв. Ингэвэл Бразил явсан хэд хөлбөмбөг үзсэн, Солонгос руу аялсан гэх элдэв хардалт сэрдэлт алга болох учиртай. Нэг хүн томилолтоор явлаа гэхэд л ямар зорилгоор явсан бэ гэдгийг тэр дор нь мэдээлээд байж яагаад болохгүй гэж. Нийслэлийн Засаг дарга асан Э.Бат-Үүл тухайн үед “Ард түмэн үнэхээр нэхэл хатуутай болжээ. Тэд төлсөн татварынхаа мөнгийг үр ашигтай зарцуулах асуудалд анхаарал хандуулдаг болсон байна” хэмээн дуу алдаж байсан. Тиймээс бид нүдэн балай чихэн дүлий байдаг иргэд биш болсон шүү. Татвар төлөгчид хууртагдахаасаа өнгөрсөн гэдгийг МАН-ынханд нэг сануулчихъя.



[www.facebook.com/PCmallOfficial](http://www.facebook.com/PCmallOfficial)  
[www.instagram.com/PCmall\\_Official](http://www.instagram.com/PCmall_Official)

Биднийг дагаарай 7575-3535

Хаяг: PC Mall төв: Их сургуулийн гудамж 31/1, Ш/Х: 346, Улаанбаатар - 14193, Сүхбаатар дүүрэг - 8

#### ИЛҮҮ ИХИЙГ БҮТЭЭХ ХҮЧ

INSPIRON 3000 SERIES

**Бид таны ажлыг хөнгөвчилнө**  
Inspiron 3000 загварын авсаархан, хөнгөхөн нөүтбүүкүүд нь таны хэрэгцээнд тохируулсан HD LED дэлгэц, Intel® процессортой учир таны төсөөлснөөс ч илүүг бүтээж чадна.

**Онцгой урамшуулал**  
Dell брэндийн 3000 серийн нөүтбүүк худалдан аваад Targus брэндийн үүргэвчийг бэлгэнд аваарай.

**Бэлгэнд**

- Үүргэвч
- 2 жилийн баталгаа
- McAfee вирусын програм

## MMINFO

Тал нутгийн цахим мэдээлэл





"Эх орон 52" Радио хүлээн авагч нь Монгол Улсад 1950, 1960, 1970 онуудад нутагшиж-ашиглагдаж байсан

# МЭДЭЭЛЭЛ



"ВЭФ 206" Радио хүлээн авагч нь Монгол улсад 1980, 1990, 2000 онуудад нутагшиж-ашиглагдаж байсан



"Di-Wave 100" Тоон радио хүлээн авагч нь Монгол Улсад 2010, 2020 онуудад нутагшиж-ашиглагдаж байна

# О.ГАНХҮҮ: МҮОНРАДИО СУВГИЙН ТООГОО НЭМСЭН Ч, СОНСОГЧДЫН ТОО БУУРСААР БАЙНА

-РӨН-ийн нэвтрүүлэг бэлтгэх дамжлага тоон технологид шилжиж, нэвтрүүлгийг дамжуулах болон хүлээн авах төхөөрөмжүүд аналог хэвээрээ байна-

Монгол Улсын зөвлөх инженер, "Дэлхийн тоон радио Монголд" ТББ-ын тэргүүн О.ГАНХҮҮ

Засгийн газрын 2010 оны 275 дугаар тогтоолоор "Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг баталсан билээ. Уг хөтөлбөрийн үндсэн зорилго нь 2014 оны долдугаар сарын 31 гэхэд радио, телевизийн өргөн нэвтрүүлгийн аналог технологийг тоон технологид шилжүүлэх, сувгийн тоог нэмэх гэсэн үндсэн заалттай бөгөөд өнөөдрийн байдлаар уг хөтөлбөр бүрэн хэрэгжиж дуусаагүй байгаа болно. Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэхэд эрх зүйн орчинг бүрдүүлэхээс гадна техник технологийн шинэчлэл нь цогц шийдийг хэрэгжүүлснээр тавьсан зорилгоо хэрэгжүүлэх боломжтой юм. Өөрөөр хэлбэл радио, телевизийн тоон студи-архивын орчинд бэлтгэсэн нэвтрүүлгийг тоон дамжуулах станц-антенн фидерийн төхөөрөмжөөр (газрын, кабелийн, сансрын) түгээж сонсогч, үзэгчдийн хүлээн авах төхөөрөмж нь тоон радио хүлээн авагч болон бидний ашиглаж байгаа set-top box-той LCD, LED эсвэл DVB-T2 стандартыг дэмждэг хавтгай зурагтууд болно. Энэ утгаараа телевизийн өргөн нэвтрүүлэг хөтөлбөр хэрэгжих хугацаандаа тоон технологид шилжсэн ба харин радио өргөн нэвтрүүлгийн хувьд өнөөдрийн байдлаар зөвхөн радио нэвтрүүлэг бэлтгэх тоон студи-архивын дамжлага л тоон технологид 2014 оны долдугаар сарын 31 гэхэд шилжсэн болно. Тоон радио дамжуулах станцын хувьд 2013 онд Баян-Өлгий аймгийн 60 квт-аналогич станц 150 квт-ын тоон дамжуулах станцаар шинэчлэгдсэн болно. Монгол Улсын РӨН-ийн 1-р сувгийг орон даяар дамжуулдаг урт болон дунд долгионы үндэсний сүлжээний бүрэлдэхүүн

хэсэг болох Улаанбаатар, Дорнод, Өмнөговь, Говь-алтай, Хөвсгөлийн дамжуулах станцууд шинэчлэгдээгүй ба мөн МҮОНРадиоогийн 2-р сувгийг орон даяар дамжуулдаг богино долгионы Улаанбаатар, Говь-Алтай, Хөвсгөлийн радио станцууд ч шинэчлэгдээгүй болно. Түүнчлэн МҮОНР-ийн 3-р суваг буюу Улаанбаатар хотод нэвтрүүлгээ цацдаг P3 -100.9 Мгц, МҮОНР-ийн 1-р сувгийг дамжуулдаг 106.1 Мгц хэт богино долгионы станцууд ч шинэчлэгдээгүй болно. Хүлээн авагч буюу тоон радио хүлээн авагчийн хувьд байдал бүр дор, Монгол Улсын хэмжээнд 1990 оноос хойш ихэнх нь БНХАУ-аас оруулж ирсэн техникийн стандарт шаардлага хангахгүй аналогич радио хүлээн авагч ашиглагдаж байна. Эдгээр техникийн шалтгаанаас болж МҮОНРадиоогийн нийт уран бүтээлчдийн ажлын үр дүн үнэгүйдэж олон нийтийн өмнө хуулиар хүлээсэн үүргээ гүйцэтгэж чадахгүй болоод байгаа болно. Хэрвээ засгийн газрын үндэсний хөтөлбөрийг хугацаанд нь хэрэгжүүлсэн бол нийт радио сонсогчид, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эхрлэгчид, контент үйлдвэрлэгчид ямар үр ашиг хүртэх талаар тодруулбал:

**А) Радио сонсогчдын хувьд**  
-Радио сонсогчдын CD дуугаралтын чанар буюу аналогич дохиотой адил сонсогдолт муутай шуугиантай дохио (хуушуур хайрах), эсвэл өөр нэвтрүүлэх станцтай долгион давхцах, өдөр шөнө, өглөө орой, өвөл зуны улирлаас хамааран нэвтрүүлгийн сонсогдолт өөрчлөгддөг гэм мэт асуудлууд огт байхгүй болно. Энэ нь олон давтамжит тоон COFDM модуляци, MPEG4 ААС кодлол зэрэг тоон техник, технологийн шийдийн үр дүн юм.  
-Тоон радио хүлээн авагчийн дэлгэц дээр текст, зураг

...МҮОНР-ийн 3-р суваг буюу Улаанбаатар хотод нэвтрүүлгээ цацдаг P3 -100.9 Мгц, МҮОНР-ийн 1-р сувгийг дамжуулдаг 106.1 Мгц хэт богино долгионы станцууд ч шинэчлэгдээгүй болно...

(зарлал, реклам, замын түгжрэл, цаг агаарын мэдээлэл) гэх мэт, Journaline- Сэтгүүл, богино хэмжээний дүрс зэрэг өгөгдлүүдийг харах боломжтой. Цаашид интерактив горимд сонсогч бүр жишээ нь Говь-Алтай аймгийн Цогт сумын Баян-Өндөр багийн Алаг-чулуут өвөлжөөнд буй малчин тоон радио хүлээн авагчаа ашиглан МҮОНРадиоогийн студи-тэй шууд харьцаж тулгарч буй асуудлаа шийдэх гэх мэт.  
-Станцын нэрээр юм уу, эсвэл оноосон нэрээр сонсох дуртай сувгаа сонгох боломжтой. Жишээлбэл, МҮОНРадиоогийн 1-р сувгийг урт долгионы 164кгц дээр Улаанбаатар хот- төвийн бүсэд, Дорнод, Өмнөговь, Баян-Өлгий аймагт урт долгионы 209 кгц дээр, Говь-алтай аймагт урт долгионы 227 кгц дээр, Хөвсгөл аймагт дунд долгионы 882 кгц дээр

өнөөдрийн байдлаар 4 өөр дамтамж дээр сонсож байгаа бол тоон радио хүлээн авагчаар " МҮОНРадио 1-р суваг" гэсэн ганц нэрээр үндэсний хэмжээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт хаана ч сонсох боломжтой болох юм. Энэ нь шаардлагатай долгионоо хайж цаг алдахгүй болно.  
**В) Радио өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн хувьд,**  
-40-50 хувь хүртэл энергийн болон ашиглалтын зардлаа багасгана. Энэ хэмжээгээр төсөв мөнгөний хэмнэлт гарна. Өөрөөр хэлбэл, РТҮСүлжээ УТУГазрын хувьд МҮОНРадиоогийн 4 сувгийн нэвтрүүлгийг нэг давтамжийн сүлжээгээр явуулснаар олон тооны дахин дамжуулах станцыг зогсоож, тэдгээр дээр ажилладаг хүмүүсийн давхардлыг арилгах юм.  
-DRM горимд долгион тархалтын хангалттай бүсийг хамруулах учир радио сонсогчдын тоог эрс нэмэгдүүлнэ. Өнөөдөр МҮОНРадио нийт 4 сувагаар нэвтрүүлгээ явуулж байгаа: Урт дунд долгионы 1-р суваг ( 164,209,227,882 кгц) тус бүр дээр, богино долгионы 2-р суваг (7260, 4895, 4830кгц) тус бүр дээр, Хэт богино долгионы -FM 3-р суваг( 100.9, 106.1мгц) тус бүр дээр, богино долгионы гадаад нэвтрүүлгийн 4-р суваг (12015, 12085кгц) тус бүр дээр нийт 11 өөр долгионыг ашиглан нэвтрүүлгээ явуулж байгаа болно. Тэгвэл тоон технологид шилжсэнээр дээрхи 11 давтамжаас зөвхөн нэгний нь л ашиглаж 4 сувгийн нэвтрүүлгээ нягтруулан орон

даяар цацах ба зөвхөн Улаанбаатар хотод нэвтрүүлгээ цацдаг FM сувгийн нэвтрүүлгийг орон даяар цацахаас гадна суларсан 10 давтамжаа өөр зориулалтаар ашиглах боломжтой болно. Давтамж нь байгалийн хязгаарлагдмал нөөцтэй баялгийн хувьд хамгийн үнэ цэнэтэй бүтээгдэхүүн юм.  
**С) РӨН-ийн контент үйлдвэрлэгчдийн хувьд**  
-Олон хэл дээр нэвтрүүлэг явуулах боломжтой: МҮОНР-ийн хувьд орон нутагт казах хэл дээр олон улсын хувьд монгол, орос, хятад, англи, япон дээр нэмэлт өгөгдлүүдийн хамт явуулах бололцоотой.  
-Тоон урсгалаа ашиглан, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжууд. Нэгэнт цаг хугацаа, хөрөнгө мөнгө зарцуулж хийсэн нэвтрүүлгээ бусад тоон медиа болгож түгээх, нэмэлт орлого олох: CD, DVD болгох Web streaming, VOD-Voice on demand үйлчилгээ үзүүлэх гэх мэт.  
-Гамшиг ослын үед автоматаар Онцгой байдлын ерөнхий газрын мэдээллийг дамжуулах.  
РӨН-ийг аналогич технологийн тоон технологид шилжүүлснээр радиогийн бусад медиагаас давуу тал болох агаарын долгионыг ашиглан алс хол зайд мэдээлэл хүргэдэг онцлог нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах чухал нөхцөл болно. Хэзээ ч гарч болзошгүй газар хөдлөлт, хүн малын гоц халдварт өвчний хорио цээрний үед тоон радио хүлээн авагчийн тусламжтайгаар ард иргэд шаардлагатай мэдээлэл, зааварчилгааг цаг тухайд нь хүлээн авч амь нас, эд хөрөнгөө хамгаалах юм. ОБЕГ-аас дамжуулсан тусгай дохионы тусламжтайгаар (эдгээр дохиог

дамжуулах төхөөрөмжүүд нь МҮОНРадиоогийн төв аппаратын болон МУОНТелевизийн төв аппаратын өрөөнд суурилагдсан) тоон радио хүлээн авагч нь унтраатай үедээ ч автоматаар асч дээр дохио мэдээллийг дамжуулна. Нөгөө талаас тоон радио хүлээн авагчийн үндсэн хэрэглэгч болох 180000 гаруй малчин, тариаланч өрх эдгээр өрх гэр бүлийн хүүхдүүдийн хувьд тоон радио хүлээн авагч нь алсын зайн сургалтын багшийн үүргийг гүйцэтгэх юм.  
ХХЗХорооноос Монгол Улсад DRM30 стандартыг урт, дунд, богино долгионд, DAB+ стандартыг хэт богино долгионд ашиглахаар шийдвэрлэсэн. Ийм учраас дээрх стандартуудыг дэмждэг тоон радио хүлээн авагчийг Монгол Улсад үйлдвэрлэх, эсвэл импортлох асуудлын нэгийг сонгох хэрэгтэй байгаа ба тоон радио хүлээн авагчийн үндсэн хэрэглэгчийн тоо бага учир тоон радио хүлээн авагчийг Монгол Улсад үйлдвэрлэх нь эдийн засгийн хувьд үр ашгийг болно. Харин импортлох асуудлыг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад тааруулан сонгох хэрэгтэй. Өнөөдөр дэлхий дахинд DRM30 стандартын тоон радио хүлээн авагч дунджаар 100-150 евро, харин DAB+ стандартын тоон радио хүлээн авагч 10-15 евро байгаа бөгөөд цаашид ч хямдрах чиг хандлагатай байгаа болно. Цаашид Монгол Улсын РӨН-ийн үндсэн сүлжээ болох Улаанбаатар, Дорнод, Өмнөговь, Говь-Алтай, Хөвсгөлийн урт, дунд долгионы станцуудыг тоон дамжуулах станцаар шинэчлэх асуудлыг, уг асуудлын холбогдох байгууллагууд болох РТҮСүлжээ УТУГазар, МТШХХГазар, ХХЗХороо, МҮОНРТелевиз, ОБЕГ-аас хамтарсан ажлын хэсэг гарч асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх гарц болох юм.

МҮОНРТелевиз, ТТөв

MMINFO. ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ

MMINFO АПП  
Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

TATA PLAY STORE  
TATA APP STORE



# ОНЦЛОХ ХУУДАС

## ДИФЛЯЦИ ТҮР ЗУУРЫНХ УУ, УДААН ҮРГЭЛЖЛЭХ ҮҮ

### Эсрэг тэсрэг байр суурь



**Б.Эрдэнэбат: Дифляци байнгын шинжтэй байх магадлал өндөр байна**

*/МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн профессор/*

Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр энэ оны эхний хагас жилд өмнөх оны мөн үетэй харьцуулбал өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн төвшин буурах үзэгдэл буюу дифляцитай болсон. Хэдхэн жилийн өмнө инфляци толгойн өвчин байсан юм. Инфляци өндөр байх нь бага, дунд орлоготой иргэдийн амьдралд сөрөг нөлөөтэй. Дифляци ч сайн зүйл биш. Гадаадын хөгжсөн орнуудад инфляцийн төвшнийг нам дор, тогтвортой байлгахыг зорьдог. Тухайлбал, жилийн инфляцийг АНУ-д гурав, Европын холбооны орнуудад 2.5-3 хувьд барихаар зорьж буй юм. Харин Японд дифляци тулгамдсан асуудал байдаг. Манай улс хэрэглээний сагсан дахь бараа бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөр инфляцийн төвшнийг тодорхойлж байгаа. Энэ сагсанд мах, гурил, будаа, хүнсний ногоо зэрэг бидний өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн багтдаг. Одоогийнх шиг үнэ буурах үед хэрэглэгчид бараа бүтээгдэхүүн худалдан авахаа хойш тавих хандлагатай болно. Өөрөөр хэлбэл, үнэ хямдрахаар нь худалдан авъя хэмээн хүлээх сонирхол нэмэгдэнэ гэсэн үг. Нөгөө талаас, ийм үед компанийн эзэд бизнесээ өргөжүүлэх, технологио шинэчлэх хөрөнгө оруулалт хийхээ азнадаг. Дифляци нь хувийн хэрэглээ болон хөрөнгө оруулалтад ийм сөрөг нөлөөтэй. ДНБ нь хувийн хэрэглээ, хөрөнгө оруулалт, Засгийн газрын хэрэглээ, цэвэр экспорт гэсэн дөрвөн хэсгээс бүрддэг. Дифляци удаан хугацаагаар үргэлжилбэл эдийн засгийн өсөлтийг хангадаг энэ дөрвөн моторын хоёр нь хүнд байдал орно. Тиймээс үнийн төвшин буурах үзэгдэл нь зуурдынх уу, урт хугацааных уу гэдгийг судалж тогтоох ёстой. Зуурдынх бол сандрах зүйл байхгүй. Харин байнгын шинжтэй бол анхаарах нь чухал юм. Эдийн засгийн нөхцөлөөс харахад энэ нь байнгын шинжтэй байх магадлал өндөр байна. Эдийн засаг нийт эрэлт болон нийлүүлэлтээс бүрддэг. Уул уурхайн бараа бүтээгдэхүүний үнэ хямдарсантай холбоотойгоор нийлүүлэлт багасаж байгаа. Зах зээлийн жамаар үнэ өсөх ёстой атал хямдарч буй нь эрэлт, нийлүүлэлт зэрэг агшиж буйг илтгэнэ. Энэ бол эдийн засгийн хямрал ойрхон байна гэсэн үг.

...Дифляци нь хувийн хэрэглээ болон хөрөнгө оруулалтад ийм сөрөг нөлөөтэй. ДНБ нь хувийн хэрэглээ, хөрөнгө оруулалт, Засгийн газрын хэрэглээ, цэвэр экспорт гэсэн дөрвөн хэсгээс бүрддэг...

...Хасах утгатай инфляци буюу дифляцийг товчхоноор үнийн төвшний бууралт гэж хэлж болно. Хэдийгээр зах зээлд үнийн төвшин буурах нь сайн зүйл гэж харагдах боловч удаан үргэлжилбэл энэ нь эдийн засагт олон эрсдэл дагуулдаг...



**Монгол банк: Дифляци улирлын чанартай**

Үндэсний статистикийн хорооны мэдээлснээр наймдугаар сард хэрэглээний үнийн улсын индекс буюу инфляци -0.6 хувьд хүрлээ. Ингэснээр Монгол Улс ах зээлийн нийгэмд шилжсэн 26 жилийн түүхэндээ анх удаа дифляцийг харж байна. Хасах утгатай инфляци буюу дифляцийг товчхоноор үнийн төвшний бууралт гэж хэлж болно. Хэдийгээр зах зээлд үнийн төвшин буурах нь сайн зүйл гэж харагдах боловч удаан үргэлжилбэл энэ нь эдийн засагт олон эрсдэл дагуулдаг. Энэ утгаараа дифляци тийм ч сайн, сайхан зүйл биш юм. Тэгвэл яагаад ийм нөхцөл байдал бий болсон бэ. Монголын эдийн засаг улирлын мөчлөгтэй. Есдүгээр сар бол хичээл, сургууль эхлэх цаг. Өөрөөр хэлбэл, малчид малаа нядлаад, хүүхдийнхээ сургалтын төлбөрийг төлөх цаг юм. Эрэлт бага байгаа үед нийлүүлэлт ихсэхээр үнэ буурдаг нь эдийн засгийн энгийн логик. Өөрөөр хэлбэл, наймдугаар сард махны нийлүүлэлт нэмэгдсэнээр үнэ нь буурчээ. Харин махны үнийн бууралт инфляцид өндөр нөлөөтэй. Эдийн засагчид Монголыг дифляциас айх хэрэггүй гэдгийг хэлж байна. Түүнчлэн энэ удаагийн дифляци түр зуурын шинжтэй гэдгийг онцолжээ. Тухайлбал, эдийн засагч Н.Дашзэвэг "Малчид оюутан хүүхдийнхээ төлбөрийг төлөх гэж малаа зардаг. Их хэмжээний мах зах зээлд нийлүүлэгдэхээр махны үнэ буурах нь тодорхой. Мөн ногоо хураалтын цаг. Тийм учраас хүнсний ногооны үнэ доод хэмжээнд хүртэл буурдаг" гэсэн байна. Түүнчлэн эдийн засагч Ж.Дэлгэрсайхан "Дифляци манай улсын хувьд түр зуурын үзэгдэл. Эдийн засаг сэргэхэд инфляци алдчихгүй л бол өөр аргаар байх зүйл бидэнд байхгүй" гэжээ. Харин эдийн засагч Ч.Хашчулуун "Дифляци мэдрэгдэж эхэллээ гэдэг мэдээллээс болгоомжлох хэрэггүй. Улирлын шинж чанартай зүйл. Энэ жилийн хувьд оюутны тэтгэлэг байхгүй учраас малчид малаа илүү ихээр зарж байна" гэж хэвлэлд ярьсан байна.

### Сэтгүүлчийн дүгнэлт

## ДИФЛЯЦИАС ХЭЗЭЭ ГАРАХ ВЭ

Н.ПУНЦАГБОЛД

Үндэсний статистикийн хороо сар бүр инфляцийг тооцохдоо монголчуудын өргөн хэрэглээний 329 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийн дундаж өөрчлөлтөөр тооцдог. Сар бүр эдгээр 329 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний заримынх нь үнэ буурч, зарим нь өсч байдаг. Тэдгээр 329 бүтээгдэхүүний үнийн өсөлт, бууралтын дундажар инфляцийн дүн гарч ирнэ гэсэн үг. Монголчуудын хамгийн өргөн хэрэглэдэг мах, ногоо, хүнсний бүтээгдэхүүний үнэ хэрхэн өөрчлөгдөх нь хэрэглээний сагсанд 30 хувийн зай эзэлдэг. Тэгвэл наймдугаар сард мах, ногоо, голлох хүнсний бүтээгдэхүүний үнэ буурсан нь инфляци хасах утгатай болох шалтгаан болжээ. Энэ бол Монголбанкнаас өгч буй мэдээлэл. Ерөөсөө Улаанбаатар хотын жилийн инфляци -0.6 хувь болж, дифляци болсны ганц шалтгаан нь мах, ногооны үнэ буурсантай холбоотой гэдгийг тоо баримтаас харж болно. Уг нь Монголбанк инфляцийг долоон хувьд барина гэсэн зорилттой байгаа юм.

Гэтэл Улаанбаатар хотын суурь инфляци 2016 оны наймдугаар сарын 31-ний байдлаар 0.8 хувьтай байгаа. Нөгөө зорьж байгаа тооноос бараг ес дахин бага гэсэн үг. Дээрээс нь наймдугаар сарын болон жилийн инфляци хасахтай гарчихаад байдаг. Улаанбаатар хотын инфляци гэдэг Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлыг тэр чигт нь тодорхойлно. Тийм болохоор энэ тоо баримтаар жишээ аваад байна. Одоо дифляци удаан үргэлжлэх үү, үгүй юу гэдэг асуулт энд урган гарч ирээд байгаа юм. Мэдээж удаан үргэлжилбэл хортой. Сайн л байна гэж байхгүй. Эдийн засагчдын зарим нь байнгын шинжтэй болох нь гээд халаглаад байдаг. Монголбанк болохоор зарим эдийн засагчдын яриаг иш татаж, түр зуурын, улирлын шинжтэй л гээд байна.

Хэрвээ тийм бол хамаа алга. Харин удаан үргэлжлэх шинжтэй боляж гарах вэ гэдэг асуулт гарч ирнэ. Өнөөх дифляци руу чирж оруулаад байгаа мах, ногооны үнэ ес, аравдугаар сард лав нэг их өсч алахгүй байх. Бүр он дуустал ч үргэлжилж магадгүй. Өнөөдөр зарим сүлжээ дэлгүүр монгол төмсийг 260 төгрөгөөр зарж байна. Тэр ч битгий хэл төмс тарьсан ногоочид үнэгүйддээ гээд бараг хаяж байгаа ч сураг гарсан. Шуудай төмсийг 5000 төгрөгөөр л зарж байгаа бололтой юм. Тэгэхээр энэ оныг дуустал үнэ нь өсөх нь юу л бол. Махны үнэ ч гэсэн одоо улам л хямдарна. Аравдугаар сарын дунд үе, арваннэгдүгээр сарын эхээр идэшний сезон. Тэр үед махны үнэ улам л хямдарна уу гэхээс нэмэгдэнэ л гэж байхгүй. Ингэхээр он дуустал, магадгүй хавар болтол ч өмнөх жилүүдийнхээ үнд тулж очихгүй ч байж магадгүй. Ингээд л үнэ нь улам буурч, хасах руу ороод байвал дифляциас гарах тухай ойрдоо ярилтгүй болох гээд байна. Дээрээс нь гайгүй өсөлттэй байгаа мах, хүнс, шатахуунаас бусад бараа бүтээгдэхүүний үнэ ч улам буурах магадлалтай байгаа. Засгийн газар төсвөө хэмнэж чадахгүй үрэлгэн хэвээр нь баталсан.

Харин Монголбанк мөнгөний бодлогоо одоохондоо зөөллөөгүй байна. Ядаж байхад Засгийн газар бонд гаргаад, дотоодын банкуудаас мөнгө босгохоор болчихлоо. Одоо иргэдэд зээл олдохгүй болох нь тодорхой. Ингэхээр нэгэнт бэлэн мөнгөгүй, худалдан авах чадваргүй болчихсон хүмүүс улам л хэцүүдэнэ. Худалдан авах чадвар нь буурна. Ингээд ирэхээр хүссэн хүсээгүй бараа бүтээгдэхүүний үнэ буурна. Тэгэхээр зарим эдийн засагчдын хэлээд байгаа шиг дифляци байнгын шинжтэй байх магадлал өндөр байна гэж яриад байгаа нь үнэн юм биш үү. Тиймээс дифляциас гарах арга замаа эртхэн хайж олох нь хамгийн зөв шийдэл байх. Тэгэхгүй бол Монголын эдийн засаг сүйрч эхэллээ. Удвал живэх нь.



# ДЭЛХИЙ

## Чандрын үнсийг дуудлагаар худалджээ

1961 онд дэлгэцнээ гарч байсан "Breakfast at tiffany's" киногоор олонд танигдсан АНУ-ын зохиолч Труман Капотегийн чандрын үнсийг Лос Анжелес хотноо дуудлагаар худалджээ. Гэтэл уг үнс итгэмээргүй үнэд буюу 43750 ам.долларт хүрч зарагдсан байна. Худалдааг Julien's Auctions компани зохион байгуулсан бөгөөд анх удаагаа алдартны чандрын үнсийг худалдсан нь энэ байжээ. Зохиолч Жонни Карсонд "Би үнс болж тавиур дээр хэвтэхийг хүсэхгүй байна" гэж ярьж байжээ.

түүний найз жүжигчин Жонни Карсон япон модон саванд хийн хадгалж байжээ. Гэвч өнгөрсөн жил тэрээр өөд болсон тул энэ удаагийн дуудлага худалдааг зохион байгуулжээ. Нэрт зохиолчийн чандрыг дотоод гадаадын маш олон үнэт ховор зүйл цуглуулагчид сонирхон оролцжээ. Гэхдээ одоогоор хэн худалдан авсан нь тодорхойгүй байна. Зохиолч Капоте амьд худалдсан нь энэ байжээ. Зохиолч Жонни Карсонд "Би үнс болж тавиур дээр хэвтэхийг хүсэхгүй байна" гэж ярьж байжээ.

## Хятад дэлхийн хамгийн том телескопыг суурилуулав

Дэлхийн хамгийн гэх тодотголтой олон бүтээн байгуулалтууд урд хөршид баригдаж, тэр хэрээр жуулчдын анхаарлыг ихээр татах болсон. Тэгвэл дэлхийн хамгийн том радио дуран /телескоп/ мөн л Хятадад баригджээ. Тус улсын баруун өмнөд этгээдэд байрлах Гуйжоу мужийн уулс хооронд дэлхийн хамгийн том телескопыг суурилуулсан бөгөөд уг төхөөрөмжийг барьснаар сансарын судалгаа шинжилгээнд дэвшил гарах гэнэ. Радио дурангийн бүтээн байгуулалтад Хятад 1.2 тэрбум юан зарцуулжээ. Харин хэмжээ нь 30 ширхэг хөлбөмбөгийн талбайг нийлүүлсэнтэй тэнцэх юм байна. Эдүгээг хүртэл Пуэрто Рико дахь ажиглалтын дуран манай дэлхийн хамгийн том радио дуранд тооцогдож байжээ. Гэвч энэ удаагийн

Хятадын дуран түүнийг хоёр нугалсантай тэнцэх аж. Радио дуранг улсын хөгжлийн бэлгэ тэмдэг болгох зорилгоор Засгийн газраас ч ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийж, 2020 он гэхэд Хятад бие даасан сансрын станцтай болох зорилго тавьжээ. Харин эцсийн дүндээ сар руу хүн нисгэхээр төлөвлөж байгаа аж. Радио дурангийн бүтээн байгуулалтын ажил 2011 онд эхэлсэн байжээ. Сансраас ирэх дохиог "барьж авах" боломжийг бий болгож, орчны дуу чимээг намгахын тулд таван км-ын радиус дотор амьдарч байсан 10 мянга орчим хүнийг нүүлгэн шилжүүлсэн байна. Эх сурвалжуудын ярьснаар, 2-3 жилийн хугацаанд туршилтаар ажиллуулсны дараа уг байгууламжийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулж эхлэх ажээ.

# Барууныхан

## ОХУ-ЫГ ШҮҮМЖЛЭВ



Б.ДАВААХҮҮ

Сирийн хойд этгээд дэх Алеппо хотод өгч буй Засгийн газрын арми болон ОХУ-ын цэргийнхний Агаарын довтолгоон улам ширүүсч буйтай холбогдуулан НҮБ-ын Аюулгүйн зөвлөл яаралтай хуралдааныг энэ сарын 25-нд зохион байгуулжээ. Улмаар хуралдаанд оролцсон Их Британи, АНУ, Франц тэргүүтэй орны төрийн тэргүүнүүд Сирийн дайны хохирогчдын тоо улам бүр нэмэгдэж байгаад ОХУ-ын Засгийн газрыг буруутай хэмээн үзэж буйгаа илэрхийлэн, эрс шүүмжилсэн байна. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн хуралдааны үеэр АНУ-ын НҮБ дэх төлөөлөгч Саманта Поуэр ОХУ-ын Сирид явуулж буй цэргийн ажиллагаа терроризмын эсрэг тэмцэл бус "харгислал" гэдгийг онцолжээ. Мөн тэрбээр Сирид агаараас цохилт өгөхийн оронд Ерөнхийлөгч Башар ал Ассадад шахалт үзүүлж, довтолгоогоо зогсоохыг ОХУ-аас шаардсан байна. Их Британид төвтэй Сирийн хүний эрхийн байгууллагаас өгсөн мэдээллээр, энэ сарын 22-ноос Сирийн арми босогчдын хяналтад буй Алеппо хотын зүүн хэсгийг чөлөөлөх дайралтаа эрчимжүүлснээс хойш хамгийн багадаа 124 хүн амна алджээ. Хамгийн харамсалтай нь тэдний ихэнх нь энгийн иргэд байсан аж. Харин Францын НҮБ дэх төлөөлөгч "Алеппод

...Хамгийн

харамсалтай

нь тэдний ихэнх

нь энгийн иргэд

байсан аж. Харин

Францын НҮБ дэх

төлөөлөгч "Алеппод

дайны маш олон

гэмт хэрэг гарч

байна" хэмээж,

энэ аймшигт үйл

хэргийн үнэн

мөнийг тогтоож,

гэмт хэрэгтнийг

шийтгэхийг

шаарджээ...

дайны маш олон гэмт хэрэг гарч байна" хэмээж, энэ аймшигт үйл хэргийн үнэн мөнийг тогтоож, гэмт хэрэгтнийг шийтгэхийг шаарджээ.

Нөгөө талаар, НҮБ-ын хуралдаанд оролцсон ОХУ-ын төлөөлөгч Виталий Чуркин довтолгооныг эрчимжүүлэхгүйгээр тухайн хэсэгт энхтайвныг тогтоох бараг боломжгүй гэдгийг онцолж, сөргөлдөгч талуудын хооронд байгуулагдсан гал зогсоох хэлэлцээр бүтэлгүйтсэний харилцааг АНУ-ын тал үүрэх ёстой гэдгийг сануулсан байна. Тэрбээр АНУ-ын Засгийн газар Олон улсын Аль Кайда бүлэглэлийн салбар Аль Нусра Фронтыг террорист бүлэглэлийн жагсаалтаас хассаны улмаас гал зогсоох хэлэлцээр бүтэлгүйтсэн гэж шүүмжилжээ.

## Оросууд Америк зурагчны бүтээл рүү шээжээ

Өсвөр насны охид болон түүний гэр бүлийнхний нүцгэн зургаар нэрд гарсан АНУ-ын гэрэл зурагчин Жок Стургесын ОХУ-ын Москва хотноо нээгдсэн гэрэл зургийн үзэсгэлэн рүү хэсэг этгээд халдаж, гэрэл зурагчны бүтээлүүд рүү шээх зэргээр бүдүүлэг авир гарган үзэсгэлэнг нь хүчээр хаажээ. "Officers of Russia" гэх байгууллагад харьяалагддаг



гэж өөрсдийгөө танилцуулсан 20 орчим залуус үзэсгэлэн рүү халдсан байна. Тэд зурагчны бүтээлүүд бага насны хүүхдийг садар самуунд уруу татсан агуулгатай хэмээн шүүмжилж, Моксвад гаргахгүй байхыг шаарджээ. АНУ-ын Калифорнид байрлан үйл ажиллагаагаа явуулдаг гэрэл зурагчин Жок ОХУ-ын Ерөнхийлөгчийн ордны ойролцоох "Lumiere Brothers" галерейд энэ сарын 7-нд бие даасан гэрэл зургийн үзэсгэлэнгээ нээсэн байна. Тэрбээр тус улсад анх удаагаа үзэсгэлэн гаргасан нь энэ байж. Одоогоор гэрэл зурагчны зүгээс ямар нэг тайлбар хийгээгүй байгаа юм. Харин галерейн дарга "Үзэсгэлэн бага насны хүүхдийг садар самуунд уруу татсан элдэв агуулгагүй. Гэхдээ нийгэмд буруу сэдэл өгч болзошгүй тул хаах шийдвэр гаргасан" гэх мэдэгдлийг хийгээд байна.

## Онгоцны агааржуулагчаас утаа гарчээ

Б.ДАВАА

Филиппиний нийслэл Манила хотын Ниной Акино олон улсын нисэх онгоцны буудлаас Японы Токио хотын Ханэда нисэх буудлыг чиглэн хөдөлсөн зорчигч тээврийн онгоцны агааржуулагчаас утаа гарчээ. Улмаар нисгэгч яаралтай арга хэмжээ авч, хөөрснөөсөө ердөө хэдхэн минутын дараа буцаж, Манилад ослын буулт хийсэн байна. Филиппиний авиа компанийн нэгэн эх сурвалж "Нисгэгч зорчигчдын танхимд утаа гарч байна гэх мэдээлэл авсны дараа аюулгүй байдлаа хангах үүднээс буцсан" гэх тайлбарыг хэвлэлийнхэнд өгсөн



байна. Эйрбус А340-300 загварын энэхүү онгоцонд 222 хүн зорчиж явсан бөгөөд нисэх багийн 13 хүн байжээ. Түүнчлэн ослын буулт хийхэд зорчигчид бэртэж гэмтээгүй аж. Тиймээс өөр онгоцоор зорчигчдыг Япон руу тээвэрлэсэн байна. Утаа гарсан шалтгаан одоогоор тодорхойгүй байгаа ч, холбогдох албаныхан шалгалт хийж эхэлжээ.

## Ираны төв банк карт гаргана

Ираны Төвбанк түүхэндээ анх удаа улсынхаа санхүүгийн байгууллагуудад эзэлийн карт гаргахыг зөвшөөрсөн тухай тус улсын Төвбанкны тэргүүн Валиолла Сейф мэдэгдлээ. Зээлийн картууд нь 3000, 10 мянга болон 15 мянган долларынх байх бөгөөд гэдгээрийг дэлгүүрт болон онлайнгаар худалдаа хийхэд ашиглаж болох ажээ. 2015 оны долдугаар сард байгуулсан цөмийн хэлэлцээрийг Тегеран дагаж мөрдөж байгааг Олон улсын цөмийн эрчим хүчний агентлаг буюу МАГАТЭ батлан мэдэгдсэний дараа Ираны эсрэг авсан хориг арга хэмжээг энэ оны нэгдүгээр сард Европын Холбоо, НҮБ болон АНУ хэсэгчлэн цуцалсны дараа тус улсын Төвбанк ийм шийдвэр гаргалаа. Хориг арга хэмжээг цуцалсан нь Ираны хувьд нефть олборлолтоо нэмэгдүүлж, эдийн засгаа дэмжих замыг засч өгсөн юм.

# МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Улиралд

64

дугаар

Манай сонины IV улирлын захиалга үргэлжилж байна

захиалгын үнэ 18000



Монгол шуудан: 70078977  
УБ шуудан: 70127027  
Скай пост: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025



# ШУУРХАЙ МЭДЭЭ

## БААР, РЕСТОРАНЫ АЖИЛЛАХ ЦАГИЙН ХУВААРИЙГ ӨӨРЧЛӨХ ШИНЭ ЗАХИРАМЖ ГАРААГҮЙ

Н.БАТЗАЯА

*Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас баар, цэнгээний газруудыг 00:00 цагт хаах талаар өчигдөр мэдээлэл хийлээ. Энэ үеэр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга О.Нарантуяагаас зарил зүйлийг тодрууллаа.*

**-Баар, рестораныг шөнийн 00:00 цагт хаана гэсэн мэдээлэл олон нийтийн сүлжээгээр явах болсон. Энэ мэдээлэл үнэн үү. Дэлгэрэнгүй мэдээлэл өгөхгүй юу?**

-Олон нийтийн сүлжээ, зарим хэвлэл мэдээллээр баар, рестораны ажиллах цагийн хуваарь өөрчлөгдсөн гэх ташаа мэдээлэл явж байна. Хуучин Э.Бат-Үүл даргын захирамжийн дагуу 04:00 цаг хүртэл ажиллаж байгаа. Түүнээс биш шөнийн 00:00 цаг хүртэл ажиллана гэдэг худал мэдээлэл. Үүнийг дахин хэлмээр байна. Баар, рестораниуд хуучин цагийн хуваарийн дагуу ажиллах болно.

**-Иргэдээс шөнийн цэнгээний газрыг 04:00 цаг хүртэл ажиллуулах нь амгалан тайван байдал алдагдуулж байна гэсэн гомдол гаргаж байгаа. Энэ талаарх гомдол, санал ирсэн үү?**

-Тийм. Иргэд, оршин суугчдын зүгээс баар, рестораны газрыг 04:00 цаг хүртэл ажиллуулах байх тухай гомдол ирсэн. Ингэж ажиллах нь иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулж байна. Тиймээс 00:00 цаг хүртэл ажиллуулж өгөөч гэсэн гомдол ирсэн. Бид иргэдийн гомдол саналын дагуу судалгаа хийлээ. Мөн аж ахуйн нэгжүүдээс ч санал авсан. Тийм учраас ингэж шийдсэн юм.

**-Тэгэхээр иргэд 04:00 цаг хүртэл ажиллахыг зөвшөөрсөн гэсэн үг үү?**

-Бид судалгаагаа залуу, дунд, ахмад гэсэн гурван чиглэлээр явуулсан. Судалгаанаас харахад 50, 50 хувьтай байгаа юм. Гэхдээ иргэдийн ихэнхи нь 04:00

цаг хүртэл үйл ажиллагаа явуулах нь зүйтэй гэсэн санал ирүүлсэн. Гэтэл нөгөө талд аж ахуйн нэгжүүд 04:00 цаг хүртэл үйлчилгээ явуулах хүсэлтэй байгаа. Хоёр талтай асуудал юм. Бид удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж байж эцсийн шийдвэрийг гаргана.

**-Цэнгээний газрууд 04:00 цаг хүртэл ажиллах нь гэмт хэргийн гаралтыг ихэсгэх талтай юу?**

-Үгүй. Цэнгээний газрууд 04:00 цаг хүртэл ажилладаг болоод хоёр жил болж байна. Энэ хугацаанд гэмт хэргийн гаралт буурсан. Баар, ресторан шөнө болтол ажиллах нь гэмт хэрэг үүсэх магадлалтай гэж зарим хүмүүс бодох байх. Гэхдээ шөнийн цэнгээний газруудыг 04:00 цаг хүртэл ажиллах захирамж гарснаас хойш гэмт хэргийн гаралт ихэссэн зүйл алга. Одоогийн байдлаар гэмт хэргийн гаралт буурсан байна. Мөн аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдсэн. Гэхдээ үүнийг тойрсон санал гомдлууд бий. Тухайлбал, орон сууцны нэгдүгээр давхарт амьдардаг иргэдээс ирэх гомдол нэмэгдсэн.

**-Одоо хуучин захирамж үйлчилж байгаа юу?**

-Тийм. 2015 оны долдугаар сарын 9-нд гаргасан захирамжийн дагуу баар, цэнгээний газрууд шөнийн 04:00 цаг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна. Одоогоор шинэ захирамж гараагүй.

**-00.00 цагт хааснаар далд гэмт хэрэг бий болно гэж мэргэжилтнүүд үзэж байна. Энэ тал дээр тайлбар хэлбэл?**

-Ахуйн архидалт, архийг шаглах асуудал ихээр гарна. Тухайлбал, шөнийн цэнгээний газруудын цагийг хязгаарласнаар ТҮЦ болон таксид архи зардаг. Өөрөөр хэлбэл, нууцаар архи зарах нь ихэсдэг. Улмаар гэмт хэрэг эрс нэмэгддэг гэсэн цагдаагийн байгууллагын судалгаа ч бий. Сүүлийн хоёр жилд харьцангуй энэ төрлийн гэмт хэрэг багассан хандлагатай байна.

**-Одоогийн байдлаар нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг хэчнээн баар байгаа вэ?**

-Нийслэлийн хэмжээнд баар, рестораны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 1500 гаруй аж ахуйн нэгж байна. Эдгээр газрууд үүрийн 04:00 цаг хүртэл ажилладаг.

**-Шинэ захирамж хэзээ гарах вэ?**

-Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцсэний дараа эцсийн шийдвэрийг гаргана. Тэр болтол хариу өгөх боломжгүй.

### СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## ХАЛЬТИРГАА ГҮЛГААНААС БОЛГООМЖИЛ

Энэ сарын 27-ноос аравдугаар сарын 1-нийг хүртэлх цаг агаарын урьдчилсан төлвийг мэдээллээ. Энэ сарын 27-нд баруун аймгуудын нутгаар, 28-нд нутгийн төв хэсгээр, 29-нд зүүн аймгуудын зарим газраар, 30-нд баруун аймгуудын нутаг болон төвийн аймгуудын хойд хэсгээр хур тунадас орно. Салхи 28, 29-нд Алтайн салбар уул болон Арц Богдын өвөр хоолойгоор, 30-нд ихэнх нутгаар секундэд 14-16 метр хурч шороон шуурга шуурна. Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар шөнөдөө 5-10 хэм хүйтэн, өдөртөө 5-10 хэм, говийн бүс нутгийн өмнөд хэсгээр шөнөдөө 4-9 хэм, өдөртөө 14-19 хэм дулаан, бусад нутгаар шөнөдөө 0-5 хэм хүйтэн, өдөртөө 9-14 хэм дулаан байна гэж Ус цаг уур, орчны шинжилгээний газраас мэдээллээ.

## Хүүхдийн мөнгийг 60 хувьд нь олгоно

Засгийн газрын ээлжит хуралдаанаар хүүхдийн мөнгийг энэ сард багтаан олгохоор шийдвэрлэсэн. Ингэхдээ бүх хүүхдэд олгохгүй бөгөөд эхний ээлжинд 60 хувьд нь буюу 660 гаруй мянган хүүхдэд олгохоор 79.2 тэрбум төгрөг төсөвлөөд байгаа аж. Харин үлдсэн 40 хувийнх нь мөнгийг хүүгүйгээр, хугацаатай хадгаламж хэлбэрээр банкинд байрлуулж, тодорхой хугацааны дараа нөхөж олгохоор төлөвлөсөн гэнэ. Тэгэхдээ Засгийн газрын энэ шийдвэр хүүхдийн мөнгө хүлээсэн иргэдийг төөрөгдүүлдэг байгаа аж. Учир нь 2012 оны өвлөөс орон даяар амьжиргааны төвшин тодорхойлох судалгааг хийж, иргэдийг амьжиргааны төвшингөөр нь 1-20 ангилалд хуваасан. Гэвч гурван жил болоод шинэчлэх ёстой энэхүү судалгааг одоо хэр нь хийж эхлээгүй байгаа юм байна. Тиймээс иргэдийн хувьд 1-10 дугаар ангилалд багтсан хүүхдүүдэд мөнгө олгоно гэсэн мэдээлэл үнэн эсэхийг мэдэхгүй байгаа аж. Түүгээр ч барахгүй Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрынхан ч энэ асуудлыг мэдэхгүй байгаа гэнэ.

## 91 согтуу жолоочийг журамлав

Замын цагдаагийн газар амралтын өдрүүдэд нийт 632 дуудлага, мэдээ мэдээлэл хүлээн авснаас, зам тээврийн ослын 458 дуудлага бүртгэгдсэн байна. Үүнээс гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 23 бүртгэгдэж 36 хүн хүнд хөнгөн гэмтсэн. Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ зам тээврийн осолд холбогдсон жолооч найм, явган зорчигч хоёр, зам тээврийн осолд сургуулийн өмнөх насны хоёр, сургуулийн насны долоон хүүхэд өртсөн байна. Үүнээс гадна согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон нийт 91 жолоочийг илрүүлж гарч болзошгүй осол хэргээс урьдчилан сэргийлж ажиллажээ.

## 38 эрүүгийн хэргийг шалгаж байна

Авлигатай тэмцэх газар 2016 оны есдүгээр сарын 19-23-ны өдрүүдэд шинээр гэмт хэргийн шинжтэй зургаан гомдол, мэдээлэл хүлээн авчээ. Нийт 21 гомдол, мэдээллийг шалгаад дөрвөн гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, нэг гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлсэн байна. Одоо ажиллагаанд 16 гомдол, мэдээлэл шалгагдаж байгаа аж. Мөн өнгөрсөн долоо хоногт эрүүгийн 46 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас дөрвөн хэргийг яллах дүгнэлт үйлдүүлж, нэг хэргийг түдгэлзүүлэх саналтайгаар прокурорт шилжүүлжээ. Харин гурван хэргийг эрүүгийн хэрэгт нэгтгэсэн бөгөөд одоогоор 38 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа аж.

### МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ



*"Гудалж" төслийн захиалгаар Яарлагийн гүүрнээс ДЦСЗ-ын баруун талаар Ажилчны гудалжтай холбож шинээр барьсан замыг ашиглалтад хүлээлгэн өгөх ёслолын үйл ажиллагаа өчигдөр боллоо. Энэхүү үйл ажиллагаанд "Гудалж" төслийн захирал Б.Батболд болон бусад албаны хүмүүс оролцов. Сонирхуулахад тус замын ажлыг Эрдэнэзал коллани гүйцэтгэжээ.*

Гэрэл зургийг Г.АРТУУЖИНИ

## "МАК"-ийн барилга нурж, долоон хүнийг даржээ

Нийслэлийн Налайх дүүргийн VI хорооны нутаг дэвсгэрт байршилтай "Бүрд хилл" ХХК-ийн барьж байсан барилга нурж, барилгын ажил гүйцэтгэж байсан долоон хүн дарагджээ. Тэдний дөрөв нь нуруу болон цээжиндээ хүнд

гэмтэлтэй бол үлдсэн гурван ажилтан хөнгөн гэмтэл авчээ. Ийнхүү гэмтсэн ажилтнуудад Налайх дүүргийн Нэгдсэн эмнэлгийнхэн анхан шатны тусламж үзүүлээд ГССҮТ-д хүлээлгэн өгсөн байна. Энэхүү нурсан барилгын

захиалагч нь "МАК" ХХК юм байна. Одоогоор ослын дүгнэлт гараагүй байгаа боловч "Техникийн алдаа гарсан болов уу гэсэн таамаг бий" хэмээн тус дүүргийн Онцгой байдалын газраас мэдэгджээ.

## Нийслэлд 6000 гаруй айл цахилгаан хэрэглэж чадахгүй байна

Улаанбаатар хотод 12 мянган айл өрх шилжин ирсэн байна. Эдгээр өрхийн нийт 6000 гаруй нь 1-5 жил өнөөдрийг хүртэл цахилгаанд холбогдож чадахгүй байгаа аж. Эдгээр айл өрхүүдийг гэрэл цахилгаанд холбохын тулд улсын төсвөөс жилд 8-10 тэрбум төгрөгийг төсөвлөдөг хэдий ч тогтуй айлууд нийслэлд байсаар байгаа албаныхан мэдээлж буй. Дээрх айлууд цахилгаангүй аж төрж байгаагийн учир нь одоо байгаа газраа өөрийн болгох зөвшөөрөл өгөхгүй байгаагаас үүдэн цахилгаан татаж өгөхгүй байгааг иргэд хэлж байна. Тухайлбал, Баянзүрх дүүргийн 21 дүгээр хороо, Өлзийт хорооллын захын дүүргүүд лаа барин, эсвэл өлгүүрийн цэнэг дөнгөн ашигладаг. Өөрөөр хэлбэл



цахилаагүй айлуудын зарим нь нарны зайн үүсгүүр ашиглан аккумулятороор гэрлээ асаадаг ба гар утас цэнэглэх, 20 цагаас 23 цаг хүртэл гэрэл асаахад аккумуляторын цэнэг дөнгөн данган хүрэлцдэг ажээ.

## ХААН БАНК

**СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА**

Сонгон шалгаруулалт зарласан огноо: 2016.09.14

**ДОХИОЛОЛ ХАМГААЛАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЖ, СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАНГАН ХАМТРАН АЖИЛЛАХ КОМПАНИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ**

ХААН Банкны орон нутгийн салбар нэгжид ашиглагдах дохиоллын тоног төхөөрөмж бэлтгэн нийлүүлж, суурилуулах, дохиоллын системийн үйл ажиллагааг 24 цагийн турш хянаж мэдээ дамжуулах гэрээт компанийг сонгон шалгаруулах тул энэ чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг туршлагатай байгууллага, аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй байгууллагууд ХААН Банкны 50000045060000035 тоот дансанд 50,000 төгрөгийг эргэн төлөгдөхгүй нөхцөлтэй тушааж, баримтын оролцох хүсэлтийн албан бичгийн хамт Төв ХААН Банкны ресепшинд өгч, сонгон шалгаруулалтын өгөгдлийг авна уу.

Материалыг 2016 оны 09 дугаар сарын 28-ны өдрийн 12:00 цаг хүртэл Төв ХААН Банкны ресепшин хүлээн авах ба зөвхөн шалгарсан компани, аж ахуйн нэгжид бичгээр хариу мэдэгдэнэ.

Хаяг: Сүхбаатар дүүрг, 4-р хороо, Сүүлийн гудамж-25, ш/х-192 Улаанбаатар 14250

Харилцах нийгэмлэгийн утас: 1800-1917

www.khanbank.com

facebook.com/khanbank

twitter.com/khanbank

Сонгон шалгаруулалтад оролцох мэдээллийг россия@khanbank.com хаягт хандлаж авна уу.





АМЖИЛТЫН ЭЗЭН

# Б.Ууганхүү:

## Дараагийн барилдаанаа хэтэрхий их бодсон нь Японы бөхөд ялагдахад хүргэсэн байх

Н.ПУНЦАГБОЛД

Паралимпийн зуны 15 дугаар наадамд амжилттай оролцож, хоёр хүрэл медаль хүртсэн баг талирчдыг очигдөр БСШУС-ын сайд Ж.Батсуурь хүлээж авч, баяр хүргэн, хүндэтгэл үзүүлээ. Энэ үеэр паралимпийн наадмаас хүрэл медаль хүртсэн жүдо бөхийн талирчин Б.Ууганхүү, науралфтингийн төрлөөр тэн хүрэл медаль хүртсэн Э.Содномпилжээ нарт алд цэнхэр хадаг, тэнгөн аяга барьж, удахгүй Засгийн газраас тэнгөн шагналыг өгнө гэдгийг хэлсэн юм. Түүний дараа паралимпийн хүрэл медальт Б.Ууганхүүтэй цөөн хором ярилцлаа.

-Рио-2016 паралимпийн 15 дугаар наадмаас хүрэл медаль хүртсэн багтам амжилт үзүүлээ. Барилдаануудынхаа талаар эргээд нэг дурсаач?

-Энэ удаагийн паралимпийн наадамд манай жинд 12 тамирчин өрсөлдсөн. 60 кг-ын шилдэг 12 тамирчин өрсөлдсөнөөс би чансаагаараа 11 дүгээрт бичигдэж орсон. Эхний тойрогтоо эзэн орны тамирчинтай барилдах байсан. Хүндхэн барилдан болсон. Би ялсан. Тэр өдөр яагаад ч юм жиндээ их гоё орсон, сэтгэл санаа сайхан байсан, бүх зүйл таарсан. Барилданууд ч сайхан болсон. Японы бөхтэй барилдахад бага зэрэг тактикийн алдаа гаргаад хожигдчихсон болохоос бусдаар бүх зүйл сайхан таарсан. Сэтгэл зүйн хувьд барилдан болгон дээр 100 хувь өөртөө итгэлтэй байсан.

Японы бөхийг ялсан бол финалдах боломж бүрэн байсан. Тэр барилдааны өмнө тактикаа яаж боловсруулсан бэ?

Японы бөхтэй өмнө барилдаж байгаагүй. Дээрээс нь барилдааныг нь тийм ч их үзэж, хараагүй болохоор жаахан алдаа гаргачихсан. Уг нь илт давуу барилдаж явж байгаад цагийн төгсгөлд ялагдсан. Хэрвээ Японыг ялсан бол хагас шигшээд Румыны бөхтэй барилдах байсан. Тэр тамирчныг өмнө ялж байсан учраас хэрвээ энэ удаад ялчих юм бол финалд гараад ирэх юм байна гэж бодож байсан. Ингэж дараагийн барилдаанаа хэт бодчихсон маань алдаа болсон байх.

Хүрэл медалийн төлөө маш сайхан барилдаж, ердөө л 4, 5-хан секундэд цэвэр ялсан. Энэ барилдааны талаар ярьвал?

-Би тэгж хурдан ялна гэж бодоогүй. Би тэр тамирчинтай өмнө нь нэг таарч барилдаж

байсан. Тийм болохоор нэлээд удаад барилдах болов уу гэж бодож байлаа. Гэхдээ өмнө нь нэг ялж байсан болохоор энэ удаад ч ялна гэдэгтээ 100 хувь итгэлтэй байсан юм. Гэтэл дөрвөн секундэд ялчихсан. Барилдахаар татамид гарахын өмнө 66 кг-ын н.Мөнхбат ах надад нэлээд зүйл зааж зөвлөсөн. Ингээрийг, тэгээрийг, цаад бөх чинь ингэж барилддаг шүү гээд л. Баруун талдаа өмсдөг болохгүй шүү, өөрөө эхэлж мэхээ хийж барилдаарай гэдгийг ч хэлж өгсөн.

Тухайн үеийн мэдрэмжээ мэхээ хийсэн үү. Эсвэл яг ийм маягаар хийе гэж бэлтгэсэн юм уу?

-Ер нь тиймэрхүү мэх хийнэ гэсэн төлөвлөгөөтэй гарсан. Харин тухайн үед барилдааны явцад хөл нь цөмрөөд ороод ирсэн. Тэгээд л мэдрэмжээрээ л мэхээ хийгээд л ялсандаа. Угаасаа холбоо мэх хийхгүй л бол болохгүй. Ганц мэх хийгээд зөвхөн тэнцвэр алдуулаад, үнэлгээ салгах боломж бага шүү дээ. Ерөөсөө жүдо холбоо, угсраа мэх хийж байж л өрсөлдөгчөө ялдаг спорт.

Пара жүдо бөхийн талаар манай уншигчдад бага сага ойлголт өгөөч. Харах чадвараасаа хамаараад төрдорхой ангилалтай байдаг юм билээ?

Пара жүдо бөхийн спортод B1, B2, B3 гэсэн гурван ангилал байдаг. Тэр гурван ангиллын тамирчин хоорондоо холидож барилдана гэсэн үг. B1 ангилалд багтаж байгаа тамирчин бол огт хараагүй гэсэн. B2 болохоор өмнөх замаа харах төдий хараатай байна. Харин B3 болохоор сул хараатай, орчноо мэдрээд, хараад явах боломжтой тамирчид байдаг.

Таны хувьд B3 ангилалд багтдаг. Тийм болохоор мэх

хийхдээ хөл цөмөрч орж ирж байгааг харах нь байна шүү дээ? -Харна. Тэгэхдээ ихэнхдээ мэдэрнэ. Миний нэг том давуу тал бол их мэдрэмтгий байдал.

Бэлтгэлээ яаж базаадагвэ. Жудогийн үндэсний шигшээ багийн тамирчидтай хамтраад л бэлтгэл хийчихнэ биз дээ?

-Би энэ дашрамд Монголын Жүдо бөхийн холбооны ерөнхийлөгч Х.Баттулга, Монголын пара жүдогийн

Холбооны Ерөнхийлөгч Х.Цагаанбаатар нарт баярлаж явдгаа илэрхийлмээр байна. Ерөнхийлөгч Х.Баттулга пара жүдогийн тамирчдыг ч гэсэн хамруулаад, бид "Хамтын хүч амжилт" уриан дор нэгдэж чаддаг. Хамтдаа бүхий л бэлтгэлийг нэг дор хийж явдаг. Тийм болохоор шигшээ багийн ах нар болоод бэлтгэл хангагч дүү нартаа баярлаж явдгаа хэлмээр байна. Паралимпийн наадамд оролцохоор явахын өмнө Х.Баттулга Ерөнхийлөгч н.Мөнхбат ах бид хоёрыг Flux Gem дээр өглөө бүр бэлтгэл хийлгэдэг байсан. Мөн хээрийн бэлтгэл хүртэл хийлгэсэн. Хандгайтад "Говь" цогцолбор дээр бас бэлтгэлээ хийсэн.

Дараагийн Олимпийн наадамд оролцох боломж мэдээж байгаа. Оноогоо цуглуулаад, чансаагаа нэмэхийн төлөө л барилдана биз?

-Дараа оны эхээр тэмцээнүүд эхлэх байх. Одоохондоо хэзээ, хаана, ямар тэмцээн болох төлөвлөгөө нь гараагүй байна. Ямарч байсан тэмцээн уралдаандаа сайн оролцоод, дараагийн



Г.Орвог / Г.АРИУНЖИМ

Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр 12  
Шөнө 1

Нөгөөдөр  
Өдөр 13  
Шөнө 1



Намрын дунд улаагчин тахиа сарын Долоон улаан мэнгэтэй Хар хулгана өдөр. Ангараг гараг

Үс засуулбал: Өлзийтэй сайн  
Наран ургах, шингэх: 06:53 - 18:45



Өдрийн өнгө: Тухайн өдөр луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, тал, адегуус туулах, гарагийг тахиж хүүхэд үрчлэн авах, хур оруулах, дарханы үйлд сайн. Улааны үйл, төлөг тавих, торь уралдах, хиниүү харвас гаргахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, торь, бич, тахиа болой. Хол газар яваар одоосод зүүн зүгт төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээгээх буюу засуулбал өлзийтэй сайн.

Олимпийн наадамд илүү их амжилт гаргахыг хичээнэ дээ. Манай пара жүдогийн тамирчид дөрвөн жилийн хугацаанд тэмцээндээ оролцоод, оноогоо цуглуулаад л явна. Өнгөрсөн дөрвөн жилд тун цөөхөн тэмцээн болсон. Дөрвөн жилд ердөө л дөрөвхөн тэмцээн болсон. Харин Токио хүртэл


тэмцээнүүд нэмэгдэх сураг байсан. Пара жүдогийн харьцангуй цөөн тэмцээнд оролцож байж эрхээ авдаг учраас илүү өндөр шаардлагатай. Оролцсон тэмцээн болгондоо медальд хүрч байж л шигшээ 12-т багтаж, тэмцээнд оролцоно.

Advertisement for 'ТЭНГИС КИНО ТЕАТР' featuring a movie poster for 'ГАЛЗУУ ЗУГААЛГА' and a photo of a group of people.

Advertisement for the animated movie 'STORKS' featuring a white stork character and other characters in a colorful setting.

Advertisement for various movies including 'VORON', 'DEEPWATER HORIZON', 'ХАНАР', 'THE WIND RISES', and 'FRENCH REQUEST' with their respective release dates.

### Бидэнд тохиолдсон



#### Хүндхэн хөгтэй явдлууд

Нарийн бичгээр анхныхаа ажлын гарааг эхлээ ээ. Захирал дээр зочин ирэхээр нь за цай оруулж өгөх ёстой гээд лаг захирлынхаа өрөө рүү орлоо. Тэгээд зочноос нь "Та цай уух уу, кофе уух уу" гэж асуув. Нөгөө хүн маань "Кофе ууя" гэсэн юм. Захирлын өрөөнөөс гараад шүүгээгээ онгойлгосон чинь кофе дууссан байдаг юм. Дүшлш. Буцаж ороод уучлаарай кофе дууссан байна. "Та цай уух уу, ус уух уу, ундаа уух уу" гээд



Ц.Цоомоо Эркэнээ

асуучихав. Тэрхэн зуур ( ам халаад, дотроо би юу асуучихав даа, ундаа байхгүй шүү дээ дүшлш) гэж бодлоо. Гэтэл нөгөөх чинь "Ундаа ууя" гэж байна. Тэгэхээр нь "Уучлаарай ундаа байхгүй" гээд хэнэггүй зогссон чинь захирал нүүр нь түнтгийтэй улайчихсан нүүрээ дараад толгойгоо сэгсэрч харагдав. Нөгөөх маань "Тэгээд юу байгаа юм" гэхээр нь "Ус л байгаа юм байна" гэчихэв. Захирал нөгөө зочноо явуулчихаад "Аль чи гараад ундаа, кофе, цай юу байдаг юм аваад ир" гэсэн. Хөөрхий дөө их ичсэн юм шиг байгаа юм.

### ОДДЫН АМЬДРАЛ

## Бяцхан ШАРЛОТТ ГҮНЖИД хүндэтгэл үзүүлж, ёслолын бууцлага хийлээ

Их Британийн угсаа залгамжлах ханхүү Уильям гэргий Кэйт Миддлтон, ханхүү Жорж, гүнж Шарлотт нарын хамт Канадын Бритиш Колумб мужийн Виториад айлчилж байна. Айлчлал энэ сарын 24-нөөс эхэлсэн бөгөөд нисэх онгоцны буудалд ханхүүгийн гэр бүлийг Канадын Ерөнхий сайд Жастин Трюдо гэргий Софи Трюдогийн хамт угтан авч, 21 удаа ёслолын буудлага хийжээ. Тэд Канадад найман өдөр саатах юм. Тэгвэл угтан авах ёслолын үеэр дэлхийн хэвлэл мэдээлэл гүнж Кэйт Миддлтон, Софи Трюдо нарын хувцаслалтыг онцгой анхааран бичиж байлаа. Түүнчлэн ой дөрвөн сартай гүнж Шарлотт гадаад улсад хийх анхны айлчлалаа тус улсад хийж буйгаараа онцлог болж байна. Уильям ханхүү таван жилийн өмнө Канадад албан ёсны айлчлал хийж байжээ.

